

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	8
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТАРИАЛАН
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН КР-2 ТӨСЛИЙН ДАРГА
В.ҮНЭНБАТ ТАНАА

2020.02.20 № 06/539
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төсөл нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн гүйцэтгэх захирал В.Үнэнбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн удирдлага санхүүгийн тайлан, тодруулга тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2020 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Б энд С аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал, Чанарын хяналтын менежер Э.Дэлгэрцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгийг Б энд С аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний 01/11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн эрхэм зорилго нь:

Хоёр улсын Засгийн газар хооронд солилцсон НОТ бичгийн дагуу “Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх КР-2 төсөл”-ийг Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх хүрээнд 2,700.0 сая иенийн 266 трактор, 201 комбайн, 20 жижиг оврын төмсний трактор, тракторын дугуй зэрэг сэлбэг, анжис, борной, будаа ачигч, цэвэрлэгч ирснийг тариалангийн аж ахуйн нэгжид 2-4 жилд төлөх хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож эргэн төлөлтийг хуримтлалын санд төвлөрүүлэхэд оршино.

Бүрдүүлсэн сангийн хөрөнгөнөөс Япон улсын Засгийн газрын зөвшөөрлөөр технологийн парк шинэчлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх зорилгоор зарцуулдаг байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр тодорхой төслүүдийг боловсруулан Япон улсын Засгийн газарт Элчин сайдын яамаар дамжуулан хүсэлт хүргүүлж холбогдох зөвшөөрлийг авсны үндсэн дээр хөрөнгө зарцуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Америкийн нэгдсэн улсын “Quick book 2010” программ хангамж ашигладаг байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, тохруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн

эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,314,631.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 23,146.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,251,897.2 мянган төгрөгөөр буюу 69.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	7,514,175.6	2,262,275.4	-5,251,900.2
Урьдчилгаа			
Бараа материал	52,355.7	52,355.7	
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	7,566,531.4	2,314,631.2	-5,251,900.2
Өр төлбөр	2,035,792.7	1,001.3	-2,034,791.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,690,616.2	7,690,616.2	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,566,531.4	2,314,631.2	-5,251,900.2

Авлага дансны үлдэгдэл буурсан нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас авах авлага 5,243,356.4 мянган төгрөг, төлбөрт үйлчилгээний авлага 8,543.8 мянган төгрөгийн төсөл хооронд үүссэн өр авлагыг өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу цэвэрлэх бичилт хийсэн байна.

Авлага дансны үлдэгдэлд 2000-2008 онуудад үүссэн, он удаан жил болсон 2,203,301.0 мянган төгрөгийн авлагаас техникийн зээлийн үлдэгдэлтэй 17 аж ахуйн нэгж байгууллагын нийт 342,400.0 мянган төгрөгийн авлагад шүүхийн шийдвэр гаргуулж, үлдсэн 1,860,901.0 мянган төгрөгийн авлагыг Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулахаар ажиллаж байна.

Бараа материал дансны үлдэгдэлд 52,355.7 мянган төгрөгийн ашиглалтгүй байгаа хөрөнгийг Өмч хамгаалах байнгын комиссын хурлаар хэлэлцүүлэн улсын төсөвт үйлдвэрийн газарт борлуулах, шилжүүлэн өгөх, борлогдохгүй тохиолдолд актлах хүсэлт дахин гаргахаар шийдвэрлэсэн байна.

Өр авлага барагдуулах ажлын хүрээнд эзэн тодорхойгүй байсан 600.0 мянган төгрөгийг холбогдох иргэнээр төлүүлсэн байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төслийн удирдлага нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Тайлант жилд ажил гүйлгээ гараагүй, төсөл хоорондын өр авлагыг холбогдох тушаал шийдвэрийн дагуу хааж, 2020 онд хаалтын баланс хийхээр төлөвлөн Японы Засгийн газарт хүсэлт хүргүүлсэн байна.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн хэрэгжих хугацаа 2020 онд дуусах тул өр авлагын үлдэгдлийг аж ахуйн нэгж, иргэн бүрээр тулган баталгаажуулах шаардлагатай байна.

2.12. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 90 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 9,543,349.6 сая төгрөгийн зөрчилд 7,279,149.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2,264,200.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснээс 7,287,091.7 мянган төгрөгийн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 76.3 хувьтай байна.

2.14. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн

“Зөрчилгүй” дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн КР-2 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,566,531,425.46	2,314,631,178.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах		
33	АВЛАГА	7,514,175,658.46	2,262,275,411.00
33100	ТЭДС-аас авлага	5,243,356,397.46	
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,211,844,821.00	2,203,300,971.00
33300	Сангийн яамнаас авлага	53,574,440.00	53,574,440.00
33400	Монгол банк	5,400,000.00	5,400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,355,767.00	52,355,767.00
354	Хангамжийн материал	52,355,767.00	52,355,767.00
35430	Сэлбэг хэрэгсэл	52,355,767.00	52,355,767.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,566,531,425.46	2,314,631,178.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,035,792,766.51	1,001,266.51
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,035,792,766.51	1,001,266.51
413	Өглөг	2,034,191,500.00	-
41350	КР-1 төсөлд төлөх өглөг	2,034,191,500.00	
414	Урьдчилж орсон орлого	1,601,266.51	1,001,266.51
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,601,266.51	1,001,266.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,530,738,658.95	2,313,629,911.49
51	Засгийн газрын хувь оролцоо	5,530,738,658.95	2,313,629,911.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,690,616,204.00	7,690,616,204.00
51101	Өмч: - төрийн	7,690,616,204.00	7,690,616,204.00
512	Хуримтлагдсан үр дүн	(2,159,877,545.05)	(5,376,986,292.51)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,589,408,251.04)	(2,159,877,545.05)
51220	Тайлант үеийн үр дүн	(570,469,294.01)	(3,217,108,747.46)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,566,531,425.46	2,314,631,178.00

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	47,304,988.00	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,304,988.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	47,304,988.00	-
120002	Хүүгийн орлого	47,304,988.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	617,774,282.01	3,217,108,747.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	617,774,282.01	3,217,108,747.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,200.00	3,217,108,747.46
2104	КР-2 төсөл үйл ажиллагааны зардал	-	3,217,108,747.46
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,200.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	16,200.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	617,758,082.01	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тагаас, санхүүжилт	617,758,082.01	-
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	617,758,082.01	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(570,469,294.01)	(3,217,108,747.46)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(570,469,294.01)	(3,217,108,747.46)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	47,304,988.00	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,304,988.00	-
120	Нийтлэг тагварын бус орлого	47,304,988.00	-
120002	Хүүгийн орлого	47,304,988.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	617,774,282.01	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	617,774,282.01	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,200.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	16,200.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	617,758,082.01	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	617,758,082.01	-
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	617,758,082.01	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(570,469,294.01)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(570,469,294.01)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7 690 616 204,00		-1 589 408 251,04		6 101 207 952,96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7 690 616 204,00	0,00	-1 589 408 251,04	0,00	6 101 207 952,96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00
C07	Тайлант үеийн үр дүн			-570 469 294,01		-570 469 294,01
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7 690 616 204,00	0,00	-2 159 877 545,05	0,00	5 530 738 658,95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7 690 616 204,00	0,00	-2 159 877 545,05	0,00	5 530 738 658,95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0,00
D08	Тайлант үеийн үр дүн			-3 217 108 747,46		-3 217 108 747,46
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7 690 616 204,00	0,00	-5 376 986 292,51	0,00	2 313 629 911,49

ТЭМДЭГЛЭЛ

A series of 26 horizontal dotted lines for writing.